**БАГЦ: 2.: ТӨМСНИЙ ЭЛИТ ҮР**

1. Монгол улсын байгаль, цаг уур, хөрсний шинж чанар, онцлогт тохирч нутагшсан болон ирээдүйтэй сортоор батлагдсан, түүнтэй дүйцэх төмсний элит үр байх ба эрт болон дунд эртийн сортын үр нийлүүлнэ.

2. Нийлүүлэх төмсний үр нь MNS-3223.2006 стандартын шаардлагыг хангасан байна.

3. Тендерт оролцогч нь төмсний үр үйлдвэрлэгчийн тусгай зөвшөөрөлтэй ба, зөвшөөрлийн хугацаа хүчинтэй байх

4. Тендерт оролцогчийн санал болгосон үрийн техникийн тодорхойлолтын үзүүлэлт бүрийг үнэн зөв гэдгийг нотлох баримт бичгийг /үйлдвэрлэгчийн хэвлэж гаргасан танилцуулга, зураг, сертификат г.м/ ирүүлнэ.

4.1. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанарын шаардлага хангаж байгааг нотлох

а) барааны гарал үүсэл,

б) чанар

в) ургамал хорио цээрийн гэрчилгээний хуулбарыг албан ёсны баталгаат орчуулгын мэдээллийн хамт байна

4.2. Нийлүүлэхээр санал болгож буй үр нь чанар, стандартын шаардлага хангасан эсэх талаарх Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторын байгууллагын шинжилгээний дүн, түүнд үндэслэсэн таримал ургамлын үр, хорио цээрийн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байна

4.3. Гадаад орноос болон дотоодын нийлүүлэгдэх үрийн үйлдвэрлэгч нь тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон үр үржүүлэх эрх бүхий хуулийн этгээд байх ба энэ тухай баримт, нотолгоо ирүүлнэ. Албан ёсны орчуулгатай байна.

4.4. Нийлүүлэх төмсний элит үрийн талбайд хянан баталгаа хийгдсэн байна. Энэ тухай баримт нотолгоо ирүүлнэ.

4.5. Тарих үрийн технологи, зөвлөмж, үйлдвэрлэгчийн танилцуулга

- Төсөв 300.000.000 /Гурван зуун сая/ төгрөг
- Элит үрийн хэмжээ 100 тонноос доошгүй

| № | Үзүүлэлт | Нийлүүлэгчийн тодорхойлолт |
|---|---|---|
| 1. | Ерөнхий үзүүлэлтүүд<br>Таримлын нэр: **Төмс**<br>- Сортын нэр:<br>- Гарал үүсэл:<br>- Үйлдвэрлэсэн он /2023 он / | |

| | | |
|---|---|---|
| 2. | - *Таримлын сорт:* Монгол улсад нутагшсан болон ирээдүйтэй сортын үр байна.<br>- *Үрийн чанарын шаардлага:* Улсын үрийн MNS-3223:2006 стандартын шаардлагыг хангасан байна. | |
| **Элит үр** | | |
| | *1. Гадаад байдал*: Бүтэн, эрүүл, хуурай, болц гүйцсэн, цэвэр, уг сортын хэлбэр дүрс, шинж чанарыг бүрэн хадгалсан байна.<br>- Гонзгой булцуутай сортын голч 35-55 мм<br>- Бөөрөнхий булцуутай сортын голч 45-65 мм<br>- булцууны жин: гр 40-100<br>*2. Төмсний өвчин:*<br>- Фитофтор 0,5<br>- Нойтон илжрэл 0<br>- Хуурай илжрэл 0,5<br>- Цагирган илжрэл 0<br>- Энгийн цахлай гадаргуугийн 3/1 ээс дээш 1,0<br>- Хар цахлай 1,0<br>- Нунтаг цахлай 1,0<br>- Төмөрлөг толбожилт махлаг эдийн харлалт 2,0 | |
| | - *Үр тус бүрийн савлагаа:* 10 кг-аар уутанд савлаж, нийлүүлэгчийн гарал үүсэл, компаний хаяг, утасны дугаарыг заавал тодоор бичиж наасан байна.<br>- *Хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт:* Нийлүүлэгч барааг Улаанбаатар хотод зориулалтын хөргүүртэй тээврийн хэрэгслэлээр тээвэрлэн авчирч, зориулалтын хөргүүртэй агуулахад хадгалж, Захиалагчид хүлээлгэн өгөх ба Захиалагчаас олгосон зөвшөөрлийн бичгийн дагуу эцсийн хүлээн авагчид барааг хүлээлгэн өгнө. | |

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| № | Барааны нэр, тодорхойлолт | Тоо, хэмжээ | Нийлүүлэх хуваарь /Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш … хоногийн дотор/ |
|---|---|---|---|
| 1 | Төмсний элит үр | Элит үрийн хэмжээ 100 тонноос доошгүйг нийлүүлнэ | 2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 10-ны дотор буюу хаврын тариалалтаас өмнө техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлнэ |